



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Жимобайл ХХК-ийн дугаарлалтын талаар авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 74 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жимобайл ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын 9820xxxx-9879xxxx, 9320xxxx-9349xxxx багц бүхий нийт 900,000 /есөн зуун мянга/ дугаарыг буцаан авсугай.
2. Дугаарыг буцаан авсантай холбогдуулан хэрэглэгчдийг хохиролгүйгээр шилжүүлэх ажлыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор багтаан зохион байгуулахыг Жимобайл ХХК-д үүрэг болгосугай.
3. Дугаар шилжүүлэхэд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Жимобайл ХХК-ийн хэрэглэгчид сонголт бий болгох хүсэлтийг үндэслэн 8700xxxx-8711xxxx дугаарлалтын багц болох нийт 120,000 /нэг зуун хорин мянга/ дугаарыг Жимобайл ХХК-д олгосугай.
4. Дугаарыг буцаан авсантай холбогдуулан нийт 900,000 /есөн зуун мянга/ дугаарт хамаарах дугаарлалтын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тус компаниас хүсэлт ирүүлсэн хугацааг харгалзан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тооцсугай.
5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Жимобайл ХХК-тай байгуулсан сүлжээний дугаарлалтын гэрээнд холбогдох өөрчлөлтийг тусган, гэрээг шинэчлэн байгуулахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮД

Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Жимобайл ХХК-ийн дугаарлалтын талаар авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 74 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жимобайл ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын 9820xxxx-9879xxxx, 9320xxxx-9349xxxx багц бүхий нийт 900,000 /есөн зуун мянга/ дугаарыг буцаан авсугай.
2. Дугаарыг буцаан авсантай холбогдуулан хэрэглэгчдийг хохиролгүйгээр шилжүүлэх ажлыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор багтаан зохион байгуулахыг Жимобайл ХХК-д үүрэг болгосугай.
3. Дугаар шилжүүлэхэд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Жимобайл ХХК-ийн хэрэглэгчид сонголт бий болгох хүсэлтийг үндэслэн 8700xxxx-8711xxxx дугаарлалтын багц болох нийт 120,000 /нэг зуун хорин мянга/ дугаарыг Жимобайл ХХК-д олгосугай.
4. Дугаарыг буцаан авсантай холбогдуулан нийт 900,000 /есөн зуун мянга/ дугаарт хамаарах дугаарлалтын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тус компаниас хүсэлт ирүүлсэн хугацааг харгалзан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тооцсугай.
5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Жимобайл ХХК-тай байгуулсан сүлжээний дугаарлалтын гэрээнд холбогдох өөрчлөлтийг тусган, гэрээг шинэчлэн байгуулахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮД



Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР